

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Авто замын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.

1/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

“10.3.Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 10.1.6, 10.1.7-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч, хамтран ажиллана.”

2/29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг:

“29.4.Авто замын барилга байгууламжийн ашиглалтын энд зааснаас бусад асуудлыг Барилгын ерөнхий хуульд зааснаар зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Авто замын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Барилгын ерөнхий хууль,” гэж, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэг болон 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг тус бүрийн “батална.” гэсний өмнө “, барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран” гэж, 22 дугаар зүйлийн 22.8 дахь хэсгийн “санхүү, төсвийн” гэсний дараа “, барилгын” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “авто замын асуудал эрхэлсэн” гэсний өмнө “барилгын болон” гэж, мөн хэсгийн “нийслэл, орон нутгийн” гэсний өмнө “хамтран,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Авто замын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.18 дахь заалт:

“4.1.18."зураг төсөл" гэж Барилгын ерөнхий хуулийн 4.1.24-т заасныг;”

2/4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалт:

“4.1.19."зураг төсөл зохиогч" гэж Барилгын ерөнхий хуулийн 4.1.26-т заасныг;”

3/4 дүгээр зүйлийн 4.1.20 дахь заалт:

“4.1.20."зураг төслийн магадлал" гэж Барилгын ерөнхий хуулийн 4.1.29-д заасныг;”

**4 дүгээр зүйл.**Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “холбогдох эрх бүхий байгууллага” гэснийг “барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран” гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ..-ний өдөр

Улаанбаатар хот

### **АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ, ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний тухай хуулийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.

“24.7.Барилгын үйл ажиллагаанд оролцох хүсэлт гаргасан гадаадын иргэнд тусгай зөвшөөрөл олгох, бүртгүүлэх асуудлыг Барилгын ерөнхий хуульд зааснаар зохицуулна.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг:

“21.2.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 21.1.6-д заасан түр барилга байгууламжийг барихад Барилгын ерөнхий хуульд заасан холбогдох зохицуулалтыг удирдлага болгоно.”

2/27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг:

“27.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 27.1.8-д заасан барилга байгууламжийг барихад Барилгын ерөнхий хуульд заасан холбогдох зохицуулалтыг удирдлага болгоно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “эрүүл мэнд” гэсний дараа “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт:

“4.1.8.хот байгуулалтын баримт бичигт нийцүүлэн газар зохион байгуулалтын баримт бичгийг боловсруулах.”

2//25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг:

“25.6.Энэ хуулийн 25.2-25.4-т заасан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг Хот байгуулалтын тухай хуульд заасан хот байгуулалтын баримт бичигт үндэслэн боловсруулсан байна.”

3/33 дугаар зүйлийн 33.9 дэх хэсэг:

“33.9.Хот байгуулалтын тухай хууль болон Барилгын ерөнхий хуулийн шаардлагад нийцээгүй, эсхүл эдгээр хуульд заасныг зөрчиж газар эзэмшүүлэх шийдвэр гаргахыг хориглоно.”

4/44 дүгээр зүйлийн 44.11 дэх хэсэг:

44.11.Хот байгуулалтын тухай хууль болон Барилгын ерөнхий хуулийн шаардлагад нийцээгүй, эсхүл эдгээр хуульд заасныг зөрчиж газар ашиглуулах шийдвэр гаргахыг хориглоно.

**2 дугаар зүйл.** Газрын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Хот байгуулалтын тухай хууль, Барилгын ерөнхий хууль,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн “усан цахилгаан станц байгуулах,” гэснийг “усан цахилгаан станц байгуулахад барилгын үйл ажиллагаатай холбогдуулан Барилгын ерөнхий хуульд заасныг баримтлах ба” гэж, 44<sup>1</sup> дүгээр зүйлийн 44<sup>1.7</sup> дахь хэсгийн “Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйл болон барилгын холбогдох норм, дүрмийг баримтална.” гэснийг “Барилгын ерөнхий хууль болон барилгын техникийн зохицуулалтыг баримт бичгийг баримтална.” гэж, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн “ хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу” гэснийг “хэсэгчилсэн төлөвлөгөө, барилгажилтын төслийн дагуу Хот байгуулалтын тухай

хууль, Барилгын ерөнхий хууль болон” гэж, 56 дугаар зүйлийн 56.6 дахь хэсгийн “10-аас” гэснийг “30-аас” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Барилгын тухай хууль” гэснийг “Барилгын ерөнхий хууль” гэж, 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийн “Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасныг” гэснийг “Барилгын ерөнхий хуулийн 31.1.1 -д заасныг” гэж тус бүр өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Захиргааны ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/60 дугаар зүйлийн 60.7 дахь хэсэг:

“60.7.Барилгын ерөнхий хуульд заасан барилгын салбарын техникийн баримт бичгийн дүрэм, журмаас бусад норм, нормативын баримт бичигт энэ бүлэг хамаарахгүй.”

2/73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсэг:

“73.2.Энэ хуульд заасан барилга байгууламжийг төлөвлөх болон барилгын үйл ажиллагаанд хамаарах бусад харилцаанд Барилгын ерөнхий хуульд заасан холбогдох зохицуулалтыг удирдлага болгоно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-3.3 дахь заалт, 8.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8.1 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн жагсаалт

3.Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
3.1.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3.2.барилга байгууламжийн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл;	
3.3.барилга байгууламжийн угсралтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;	

2/8.2 дугаар зүйл.Энгийн зөвшөөрлийн жагсаалт

3.Барилга, хот байгуулалтын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
3.1.Барилгын ерөнхий хуульд заасан барилгын ажлын зөвшөөрөл	Засгийн газар
3.2.Барилгын ерөнхий хуульд заасан барилгын ажлын зөвшөөрөл	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3.3.Барилгын ерөнхий хуульд заасан барилгын ажлын зөвшөөрөл	Аймаг, нийслэлийн Засаг дарга
3.4.барилга байгууламжийн техникийн баримт бичгийг хэвлэх	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12.1 дугаар зүйл.Барилгын ерөнхий хууль зөрчих

1.Барилгын ажил, үйл ажиллагаанд холбогдох тусгай зөвшөөрөлгүйгээр ажил, үйл ажиллагааг эрхэлсэн, барилгын зөвшөөрөлгүйгээр барилга барьсан, шинэчлэн засварласан, буулгасан, захиалагч нь төлөвлөлтийн зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон мэргэжилтний эрхийг эзэмшигч нь тухайн зөвшөөрлөө бусдад ашиглуулах, худалдах, шилжүүлсэн бол хүнийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрөл болон мэргэжилтний эрхийг хүчингүй болгоно.

3.Барилга байгууламжийг барихдаа барилгын баримт бичигт тусгагдсан зөвшөөрлийн нөхцөл, техникийн зохицуулалт, дүрэм журам, шаардлагыг зөрчсөн, биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол барилга байгууламжид учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

4.Захиалагч, гүйцэтгэгч барилга байгууламжийг барихаар олгогдсон газрын хил хязгаар, хэмжээг дур мэдэн өөрчилсөн, нийтийн эдэлбэр газрын талбай, усны эх үүсвэр, дэд бүтцийн хамгаалалтын бүсэд холбогдох хууль тогтоомжийг зөрчиж барилгын үйл ажиллагаа явуулсан бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.Батлагдсан зураг төсөлгүйгээр барилгын ажил гүйцэтгэсэн, Барилгын ерөнхий хуульд заасан барилгад магадлал хийлгэлгүйгээр барилга угсралтын ажил эхэлсэн эсхүл нөхөж магадлал хийлгэсэн бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

6.Байгууллагын удирдлага, зургийн ерөнхий архитектор /инженер/-ийн барилгын зураг төслийг боловсруулан баталсан зураг төсөл нь алдаатай, төлөвлөлт зөрчсөн, барилга байгууламжийн техникийн баримт бичигт нийцээгүй бол хүнийг

таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Техникийн төсөл, ажлын төслийг боловсруулахдаа батлагдсан загвар төслийн зориулалт, хэлбэр, хэмжээ, давхаржилт, гудамж замын улаан шугам, дэд бүтцийн шугам сүлжээ болон бусад хязгаарлалт, хамгаалалтын бүсээс авах зай зэргийг өөрчилж төлөвлөсөн бол хүнийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл түр үйл ажиллагааг зогсооно.

8.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 11.7-д заасан барилга байгууламжийн төрлийг зөрчиж зориулалтын бус барилга байгууламжийн зураг төсөл боловсруулсан, барилгын ажил гүйцэтгэсэн, ашигласан бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

9.Захиалагч, барилгын ажил гүйцэтгэгч нь барилга байгууламжийн зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дур мэдэн өөрчилсөн, түүний дагуу барилгын аливаа үйл ажиллагаа явуулсан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Барилга байгууламжийн зураг төсөлд нөхөж магадлал хийсэн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Барилгын ажлын талбай дахь мэдээллийн самбарт мэдээлэл байршуулаагүй, эсхүл бүрэн бус мэдээлэл байршуулсан, барилгын ажилтай холбоотой мэдээллийн самбарыг зар сурталчилгааны зориулалтаар ашигласан, захиалагч, гүйцэтгэгч нь барилгын ажлын үйл ажиллагаа, түүний мэдээлэл болон бүртгэл тайлагналтыг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлээгүй бол хүнийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл барилга байгууламжийн үйл ажиллагааг түр зогсооно.

12.Өмчлөгч, эзэмшигч барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учруулах, зохих мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр үндсэн хийц, бүтээц, төлөвлөлт, зориулалтыг өөрчлөх, тухайн барилга байгууламжид байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх, ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулж болзошгүй үйл ажиллагаа эрхэлсэн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл барилга байгууламжийн үйл ажиллагааг түр зогсооно.

13.Ашиглалтын явцад барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учирсан, нурсан, захиалагч, ашиглагч, өмчлөгч, гүйцэтгэгч барилгыг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах, баталгаат засварын хугацаа дуусгавар болгохтой холбогдуулан барилгад хамтарсан үзлэг, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, баталгаат засварын хугацаа дуусгавар болгох гүйцэтгэгчийн хүсэлтэд захиалагч хариу өгөөгүй, эсхүл хамтарсан үзлэг шалгалтад оролцоогүй бол хүнийг таван мянган нэгжтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл барилга байгууламжийн үйл ажиллагааг түр зогсооно.

14.Барилга байгууламжийг ашиглагч нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр болон харилцан тохиролцоогүйгээр бусад барилга байгууламжийн инженерийн хангамжийн хэрэглээг тасалсан, хувийн хөрөнгө оруулалтаар барьсан инженерийн шугам сүлжээнээс бусдад түгээсэн бол хүнийг долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг далан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл хуулийн этгээдийн үйл ажиллагааг түр зогсооно.

15.Дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашигласан, түр барилга байгууламжийг байнгын ашиглалттай барилга байгууламж болгосон бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл барилга байгууламжийн үйл ажиллагааг түр зогсооно.

16.Хүний амь нас, эрүүл мэндэд шууд аюул учрах нөхцлийг бүрдүүлсэн, эвдэрсэн барилгыг нураах, сэргээн засварлах тухай шаардлагыг биелүүлэхгүй бол тухайн барилгыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийг хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар барилга байгууламжийн үйл ажиллагааг хязгаарлана.

17.Барилгын ерөнхий хуульд тусгайлан зааснаас бусад барилгыг бүрэн дуусгах хүртэл давхраар, температурын заадлаар хэсэгчлэн хүлээлгэж өгсөн, хүлээн авсан, зөвшөөрөлгүй баригдсан барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан, ашиглалтын гэрчилгээ олгосон эсхүл байнгын ашиглалтад оруулаагүй барилгыг цахилгаан, харилцаа холбоо, дулаан, халуун, хүйтэн усаар хангасан, барилгын ажлын зөвшөөрөл олгосон бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

18.Барилгын мэргэжилтэй ажилтан нь Барилгын ерөнхий хуульд заасан мэдээллийн санд бүртгүүлэхгүйгээр барилгын аливаа үйл ажиллагаа эрхэлсэн, барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн хяналт тавих үүргээ биелүүлээгүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрөл, эрхийг 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлана.

19.Барилгын ерөнхий хуульд заасны дагуу бүртгэлд хамрагдсан барилгын салбарын мэргэжилтэй ажилтан нь дөрөвдүгээр ангиллын барилга байгууламжаас бусад ангиллын барилга байгууламжийн ажлын хувьд бие даан барилгын үйл ажиллагаа эрхэлсэн, барилгын салбарын мэргэжилтний мэргэжлийн ёс зүй, хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг ноцтой зөрчсөн, барилгын салбарын мэргэжилтэн нь аль нэг барилгын компанид бүртгэлтэй тохиолдолд өөр бусад компанид давхардсан бүртгэлтэй нь илэрсэн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун

мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлана.

20.Захиалагч нь өөрийн чиг үүргийн хүрээнд барилгын үйл ажиллагаатай холбоотой хуурамч, буруу баримт бичгийг бүрдүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрөл, эрхийг 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлана.

21.Барилгын ажлыг зогсоох тухай улсын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлээгүй бол хүнийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлана.

22.Барилгын ажлыг гэрээгүйгээр гүйцэтгэсэн, хууль тогтоомжид заасан журмыг зөрчиж барилга барьсан, барилгын ажлын аюулгүй ажиллагааны дүрэм, журам зөрчсөн бол хүнийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлана.

23.Зах зээлд нийлүүлэх барилгын материал, бүтээгдэхүүн нь холбогдох чанар, стандартад нийцээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

24.Барилга байгууламжийн техникийн баримт бичгийн шаардлага, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч болон захиалагчийн шаардлага болон гэрээний дагуу гүйцэтгэсэн, эсхүл зохих журмын дагуу баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг үндэслэлгүйгээр саатуулсан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл барилгын ажлыг түр зогсооно.

25.Газрын зөвшөөрөл, холболтын нөхцөл аваагүй, зураг төсөл нь боловсруулагдаж дуусаагүй, даацын элемент угсралтын ажил дуусаагүй орон сууцны барилгад иргэдээс хөрөнгө төвлөрүүлсэн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл хуулийн этгээдийн үйл ажиллагааг түр зогсооно.

26.Барилга байгууламжийг барихдаа талбай, орчны болон техникийн аюулгүй байдлыг хангаагүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл барилгын ажлыг түр зогсооно.

27.Барилгын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд заасан хориглолтийг зөрчсөн эсхүл төлөвлөлтийн зөвшөөрөл, барилгын зөвшөөрлийг зөрчсөн бол тухайн барилга байгууламжийг буулгаж, үйл ажиллагааг зогсооно.

28.Импортоор оруулж ирэх, ханган нийлүүлэх барилгын гол нэр төрлийн материалд тохирлын гэрчилгээ аваагүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг түр зогсооно.

29.Барилгын ажил гүйцэтгэгч нь Барилгын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь заалт дахь үүргээ биелүүлээгүй бол хүнийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг түр зогсооно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Иргэний хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/76 дугаар зүйлийн 76.6 дахь хэсэг:

“76.6.Барилга, байгууламжтай холбоотой баталгаат хугацааг холбогдох хуульд зааснаар тогтооно.”

2/254 дүгээр зүйлийн 254.8 дахь хэсэг:

“254.8.Барилга, байгууламжтай холбоотой баталгаат хугацааг холбогдох хуульд зааснаар тогтооно.”

3/349 дүгээр зүйлийн 349.4 дэх хэсэг:

“349.4.Барилгын ажил гүйцэтгэлтэй холбоотой баталгаат хугацааг холбогдох хуульд зааснаар тодорхойлно.”

4/358 дугаар зүйлийн 358.2 дахь хэсэг:

“358.2.Барилгын ажил гүйцэтгэх болон барилга байгууламжтай холбоотой нарийвчилсан асуудлуудыг талууд харилцан тохиролцсоноор тодорхой төрлийн гэрээгээр зохицуулж болох бөгөөд Барилгын ерөнхий хуульд заасныг удирдлага болгоно.”

5/349 дүгээр зүйлийн 349.4 дэх хэсэг:

“349.4.Барилгын ажил гүйцэтгэлтэй холбоотой баталгаат хугацааг Барилгын ерөнхий хуульд зааснаар тодорхойлно.”

**2 дугаар зүйл.**Иргэний хуулийн 349 дүгээр зүйлийн “гурван жилийн дотор” гэснийг “Барилгын ерөнхий хуульд заасан барилга байгууламжийн байгууламжийн баталгаат хугацааны дотор” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 8 дугаар зүйлийн 8.6.11 дэх хэсэг:

“8.6.11.Барилгын ерөнхий хуулийн Арван гуравдугаар бүлэгт заасан мэдээлэл”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Орон сууцны тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.8 дахь хэсэг нэмсүгэй:

“9.8.Орон сууцны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилга байгууламжийг ашиглах зэрэг харилцаанд Барилгын ерөнхий хуулийг дагаж мөрдөнө.”

**2 дугаар зүйл.**Орон сууцны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль,” гэсний өмнө “Барилгын ерөнхий хууль,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Орон сууцны тухай тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.1.5."орон сууцны байшингийн орчны тохижилт" гэж Барилгын ерөнхий хуулийн 4.1.21-д заасан гадна тохижилтын ажлыг;”

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дахь хэсгийн “Барилгын тухай хууль” гэснийг “Барилгын ерөнхий хууль” гэж, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйл” гэснийг “Барилгын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйл” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.9 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2.7 дахь хэсэг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “Тайлбар”-ын “хүчин төгөлдөр стандартаас гэсний өмнө “ижил утга агуулгатай” гэж нэмсүгэй

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төмөр замын тээврийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг:

“3.3.Төмөр замын тээврийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой барилгын үйл ажиллагаанд Барилгын ерөнхий хуулийг дагаж мөрдөнө.”

2/10 дугаар зүйлийн 10.2.17 дахь заалт:

“10.2.17.энэ хуулийн 10.2.11, 10.2.15-д заасан барилгын үйл ажиллагаанд барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах.”

3/11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг:

“11.5.Энэ хуулийн 11.1.5, 11.1.6-д заасан журам, 11.1.21-д заасан нормыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

4/21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг:

“21.5.Төмөр замын суурь бүтцийн зураг төслийн үйл ажиллагаанд Барилгын ерөнхий хуульд заасан зохицуулалтыг баримтална.”

5/22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг:

“22.3.Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг гүйцэтгэхэд Барилгын ерөнхий хуулийн холбогдох зохицуулалтыг удирдлага болгоно.”

**2 дугаар зүйл.** Төмөр замын тээврийн тухай хуулийн 23.5 дахь хэсгийн “хүлээн авах улсын комиссыг” гэсний дараа “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.8 дахь хэсэг нэмсүгэй:

“3.8.Түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилга байгууламжийг ашиглах зэрэг барилгын үйл ажиллагаанд Барилгын ерөнхий хуулиар зохицуулна.”

**2 дугаар зүйл.**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсгийн “Барилгын тухай хуулийн 4.1.1-д” гэснийг “Барилгын ерөнхий хуулийн 4.1.4, 4.1.5-д” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.12 дахь хэсэг нэмсүгэй:

“12.12.энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 7-д заасны дагуу баригдсан барилга байгууламжийн үндсэн зориулалтыг өөрчлөх;”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2 дахь заалт:

“28.1.1.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгоход:

Барилга байгууламжийн ангилал	Хураамжийн хэмжээ /төгрөг/
Нэгдүгээр ангиллын барилга байгууламж	300,000
Хоёрдугаар ангиллын барилга байгууламж	200,000
Гуравдугаар ангиллын барилга байгууламж	100,000

28.1.2.барилга байгууламжийн барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход:

Барилга байгууламжийн ангилал	Хураамжийн хэмжээ /төгрөг/	Хураамжийн хэмжээ /сунгахад, төгрөг/
Нэгдүгээр ангиллын барилга байгууламж	400,000	1 400 000
Хоёрдугаар ангиллын барилга байгууламж	300,000	1 200 000
Гуравдугаар ангиллын барилга байгууламж	200,000	1 000 000

2/28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалт:

“28.1.4.өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход:

Барилга байгууламжийн ангилал	Хураамжийн хэмжээ /төгрөг/
Нэгдүгээр ангилал	200 000
Хоёрдугаар ангилал	150 000
Гуравдугаар ангилал	100 000

**2 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 28.1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Усны тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.1.31 дэх заалт:

“10.1.31.усны барилга байгууламжийн техникийн баримт бичиг, усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэхтэй холбоотой дүрэм, журмыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.”

2/16<sup>1</sup> дугаар зүйлийн 16<sup>1.5</sup> дахь хэсэг:

“16<sup>1.5</sup>.Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 16<sup>1.4.10</sup>-т заасан усны барилга байгууламж барих шийдвэрийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран гаргана.”

3/32 дугаар зүйлийн 32.11 дэх хэсэг:

“32.11.Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, усны барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх болон усны барилга байгууламжийн ашиглалттай холбоотой харилцаанд Барилгын ерөнхий хуулийн холбогдох зохицуулалтыг удирдлага болгоно.”

**2 дугаар зүйл.**Усны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “мэргэжлийн байгууллага” гэсний дараа, мөн зүйлийн 32.2 дахь хэсгийн “Засаг даргын саналыг үндэслэн” гэсний дараа “Барилгын ерөнхий хуульд заасан шаардлага, зохицуулалтын хүрээнд” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хот байгуулалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг:

“2.3.Хот байгуулалт, төлөвлөлтийн баримт бичгийн дагуу барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барьж байгуулах, барилгажилтын төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Барилгын ерөнхий хуулийг дагаж мөрдөнө.”

2/3 дугаар зүйлийн 3.1.19 дэх заалт:

“3.1.19.“барилгажилтын төсөл” гэж хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын бүсчлэлд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн барилгажуулахад тавигдах архитектур төлөвлөлтийн шаардлага бүхий баримт бичгийг;”

3/11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалт:

“11.1.10.барилгажилтын төсөл.”

4/12 дугаар зүйлийн 12.11 дэх хэсэг:

“12.11.Барилгажилтын төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

12.11.1.гудамж, замын сүлжээ, тээврийн хэрэгсэл, дугуйтай ба явган зорчигчийн хөдөлгөөн, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж, зэргэлдээ орших барилга байгууламжийн байршил, архитектуртай нь уялдуулан, тасралтгүй өсөн хөгжих хөдөлгөөнтэй, нэгдсэн системтэй байхаар тооцож, холбогдох барилга байгууламжийн техникийн баримт бичиг, дүрэм, журамд заасны дагуу төлөвлөсөн байх;

12.11.2.хот байгуулалтын бүсчлэлийн дүрэмд тусгагдсан хот байгуулалтын бүсчлэлийн дагуу тухайн хот, суурин газрын газар, талбайн ашиглалт /барилга байгууламжийн эзлэхүүн, барилга байгууламж барих эдэлбэр газрын талбайн харьцаа/, өндөржилт, зай хэмжээ, инженерийн дэд бүтцийн шийдэл, ногоон байгууламж, орчны тохижилтын төлөвлөлтийн норм, дүрмийн шаардлагыг хангасан байх;

12.11.3.тухайн нэгж талбарт барих барилга байгууламжийн болон зэргэлдээ орших барилга байгууламжийн хоорондох зайг холбогдох норм, нормативын баримт бичиг, дүрэм, журамд заасны дагуу ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулахгүйгээр төлөвлөсөн байх.

12.11.4.Барилгын ерөнхий хуульд заасан барилга байгууламжийн гадна тохижилтын ажлыг төлөвлөсөн байх;

12.11.5.гадна тохижилтын ажил, барилга байгууламжийн орц, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөний хязгаарлалттай хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлж, хүртээмжтэй орчныг бүрдүүлэн төлөвлөсөн байх;

12.11.6.барилгажилтын төсөлд ногоон байгууламж, авто зогсоолыг энэ хуульд заасны дагуу төлөвлөсөн байх.”

5/21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалт:

“21.1.5.Хот байгуулалтын хууль тогтоомжийн хүрээнд хот, суурин газарт барилгажилтын төслийг хэрэгжүүлэх, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барьж байгуулах, үйл ажиллагааг хот байгуулалтын бүсчлэлд нийцүүлэн хот төлөвлөлтийн батлагдсан баримт бичгийг үндэслэл болгох ба Барилгын ерөнхий хуулийг дагаж мөрдөнө.”

6/21<sup>1</sup> дүгээр зүйл:

#### **“21<sup>1</sup> дүгээр зүйл.Барилгажилтын төслийг хэрэгжүүлэх**

21<sup>1</sup>.1.Барилгажилтын төслийг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын бүсчлэлийн дүрэм, холбогдох норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмын дагуу боловсруулна.

21<sup>1</sup>.2.Шинээр барилга байгууламж барих, баригдсан барилга байгууламжид өргөтгөл хийх тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн хот байгуулалтын газарт барилгажилтын төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргана.

21<sup>1</sup>.3.Энэ хуулийн 21<sup>1</sup>.2-т заасан хүсэлтэд дараах мэдээллийг тодорхой тусгаж, холбогдох материалыг хавсаргана:

21<sup>1</sup>.3.1.эдэлбэр газрын нийт хэмжээ, ойр орчмын гудамжны нэр;

21<sup>1</sup>.3.2.санал болгож буй газар ашиглалт буюу барилгажилтын төсөл, эдэлбэр газар дээр байгаа болон барихаар төлөвлөж буй барилга байгууламжийн зориулалт;

21<sup>1</sup>.3.3.эдэлбэр газар дээр одоо байгаа болон барихаар төлөвлөж буй барилга байгууламжийн байршлыг заасан тойм зураг;

21<sup>1</sup>.3.4.эдэлбэр газрын хил, ойр орчмын гудамжнаас одоо байгаа болон барихаар төлөвлөж буй барилга байгууламж хоорондын зай хэмжээ;

21<sup>1</sup>.3.5.одоо байгаа болон барихаар төлөвлөж буй барилга байгууламжийн нийт талбайн хэмжээ, давхрын тоо, эзлэхүүний хэмжээ;

21<sup>1</sup>.3.6.эдэлбэр газар дээр одоо байгаа болон барихаар төлөвлөж буй барилга байгууламж хоорондын зай, өндрийн хэмжээ;

21<sup>1</sup>.3.7.барилгажилтын төсөлд тусгагдсан барилга байгууламжийн аль нэг хэсэг нь 3 болон түүнээс дээш давхар бол тухайн хэсгийн эдэлбэр газар дээрх бусад барилга байгууламж, зэргэлдээ байрлах барилга байгууламжаас ямар зайд байрлаж байгаа болон тэдгээрийн нийт эдэлбэр газрын эзэлж буй талбайн хэмжээ;

21<sup>1</sup>.3.8.эдэлбэр газар дээр байгуулах авто зогсоол, ногоон байгууламжийн тоо, хэмжээ.

21<sup>1</sup>.4.Аймаг, нийслэлийн хот байгуулалтын газар нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хянаж, дараах нөхцөлийг хангаж байгаа эсэхийг шалган баталгаажуулна:

21<sup>1</sup>.4.1.эдэлбэр газрын хэмжээ нь холбогдох хот байгуулалтын бүсчлэлийн дүрэмд заасан бүсийн эдэлбэр газрын хамгийн бага талбайн хэмжээг хангаж байгаа эсэх;

21<sup>1</sup>.4.2.тухайн газар нь Барилгын ерөнхий хуульд заасан инженерийн шугам сүлжээнд холбогдсон эсэх;

21<sup>1</sup>.4.3.санал болгож буй газрын ашиглалт нь хот байгуулалтын бүсчлэлийн дүрэмд заасан зөвшөөрөгдөх ашиглалтын жагсаалтад байгаа эсэх;

21<sup>1</sup>.4.4.барилга байгууламж нь эдэлбэр газрын байрлаж буй бүсийн төлөвлөлтийн дараах шаардлагыг хангаж байгаа эсэх:

21<sup>1</sup>.4.4.а.барилга байгууламжийн өндөр, давхрын хамгийн дээд хэмжээ, тоо;

21<sup>1</sup>.4.4.б.гудамжнаас барилга байгууламжийн хил хүртэлх хамгийн бага зайн хэмжээ;

21<sup>1</sup>.4.4.в.зэргэлдээх газар болон барилга байгууламжаас байрлах зайн хэмжээ;

21<sup>1</sup>.4.4.г.эдэлбэр газрын барилгажих талбайн хамгийн дээд хэмжээ;

21<sup>1</sup>.4.4.д.хот байгуулалтын бүсчлэлийн дүрмийн дагуу тухайн эдэлбэр газрын бүсэд хамаарах заалттай нийцэж байгаа эсэх.

21<sup>1</sup>.5.Аймаг, нийслэлийн хот байгуулалтын газар нь энэ хуулийн 21<sup>1</sup>.2-т заасан хүсэлтийг хянан үзээд хүсэлт нь энэ хуулийн 21<sup>1</sup>.4-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд барилгажилтын төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох бөгөөд

уг шаардлагыг хангаагүй тохиолдолд хүсэлтийг холбогдох материалын хамтаар хүсэлт гаргагчид буцаана.

21<sup>1</sup>.6.Барилгажилтын төсөл хэрэгжүүлэх арга хэмжээг хот байгуулалтын бүсчлэлийн дүрэм, Барилгын ерөнхий хуульд зааснаар зохицуулна.”

**2 дугаар зүйл.**Хот байгуулалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль,” гэсний өмнө “Барилгын ерөнхий хууль,” гэж 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтын “тэдгээрийн суурь судалгааг” гэсний өмнө “барилгажилтын төсөл,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2.3 дахь хэсэг нэмсүгэй.

“2.3. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой барилгын үйл ажиллагаанд Барилгын ерөнхий хуулийг дагаж мөрдөнө.”

**2 дугаар зүйл.** Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 2.1 дэх хэсгийн “Барилгын тухай” гэснийг “Барилгын ерөнхий” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль,” гэсний өмнө “Барилгын ерөнхий хууль,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 5.1.3 дахь заалтын “Барилгын тухай хууль” гэснийг “Барилгын ерөнхий хууль” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9.1. дэх хэсгийн “барилгын тухай хууль” гэснийг “барилгын ерөнхий хууль” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25<sup>1</sup> дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25<sup>1</sup>.1.6 дахь заалт нэмсүгэй:

“25<sup>1</sup>.1.6.барилгын ажлын талбайд болон ойр орчмын нутаг дэвсгэр дэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих;”

**2 дугаар зүйл.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25<sup>1</sup>.1.6 дахь заалтын дугаарыг “25<sup>1</sup>.1.6” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн 24.2 дахь хэсгийн “Хот байгуулалтын тухай, Барилгын тухай,” гэснийг “Барилгын ерөнхий хууль, Хот байгуулалтын тухай,” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 100 дугаар зүйлийн гарчиг, 100.3 дахь хэсгийн “нураах” гэснийг “буулгах” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 100.2, 100.3 дахь хэсгийн “нураах” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай 20.13<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй.

#### **“20.13<sup>1</sup> дүгээр зүйл. Зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барих**

1.Барилга байгууламжийг зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн, өөрчилсөн зураг төслөөр барилгын аливаа үйл ажиллагаа явуулсан, барилга байгууламж барихаар олгогдсон газрын хил хязгаар, хэмжээг дур мэдэн өөрчилсөн, зохих мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр барилга шинээр барьсан, бариулсан, барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээц, төлөвлөлт, зориулалтыг дур мэдэн өөрчилснөөс байгаль орчинд их хэмжээний хохирол учирсан, хүний амь нас, эрүүл мэндэд хүндэтэр хохирол учруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрхийг нэг жилээс найман жил хүртэлх хугацаагаар хасаж, хуулийн этгээдийг хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох болон төлөөлөх эрх бүхий этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**2 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 20.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нэг жилээс найман жил хүртэлх хугацаагаар хасаж, хуулийн этгээдийг хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, төлөөлөх эрх бүхий этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл ахуйн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Барилгын тухай” гэснийг “Барилгын ерөнхий” гэж, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсгийн “норм, норматив” гэснийг “барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлд” гэснийг “Барилгын ерөнхий хуулийн дөрөвдүгээр бүлэгт” гэж, 5.7 дахь хэсгийн хэсгийн “Барилгын тухай хуулийн 3.1.11-д” гэснийг “Барилгын ерөнхий хуульд заасны дагуу” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрчим хүчний тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/4/33<sup>1</sup> дүгээр зүйл:**

“33<sup>1</sup> дүгээр зүйл. Эрчим хүчний барилга байгууламжийн ашиглалт

33<sup>1</sup>.1. Эрчим хүчний барилга байгууламжийн ашиглалтыг Барилгын ерөнхий хуульд зааснаар зохицуулна.”

2/2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг:

“2.6. Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой барилгын үйл ажиллагаанд Барилгын ерөнхий хуулийг дагаж мөрдөнө.”

3/3 дугаар зүйлийн 3.1.35 дахь заалт:

“3.1.35. “эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл” гэж Барилгын тухай хуулийн 4.1.33-т заасныг.”

4/6 дугаар зүйлийн 6.1.20 дахь заалт:

“6.1.20. эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой барилгын үйл ажиллагаа болон энэ хуулийн 6.1.5-д заасан барилга байгууламжийн техникийн зохицуулалтад барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах.”

**2 дугаар зүйл.** Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “эрчим хүчний барилга байгууламж барих” гэсний дараа “тусгай зөвшөөрлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналд үндэслэн” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалтын “эрчим хүчний эх үүсвэр,” гэсний өмнө болон 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “барилга угсралтын ажлыг” гэсний дараа “Барилгын ерөнхий хуульд заасны дагуу” гэж тус тус, 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 20<sup>1</sup>.1 дэх хэсгийн “олгоно.” гэсний өмнө “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.32 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.1.32. “магадлал” гэж Барилгын ерөнхий хуулийн 4.1.29-д заасныг;”

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.9.ж дэх дэд заалт нэмсүгэй:

“9.1.9.ж.Ногоон барилга барих, эрчим хүчний хэмнэлттэй барилгын материал үйлдвэрлэхдээ Барилгын ерөнхий хуулийг баримтална.”

**2 дугаар зүйл.** Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 6.1.2 дахь хэсгийн “батлах” гэсний дараа “стандартыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 9.1.9.ж дэх дэд заалтын дугаарыг “9.1.9.з” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ  
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр баталсан Барилгын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **БАРИЛГЫН ЕРӨНХИЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө барилгын үйл ажиллагааны хүрээнд олгосон Барилгын тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл нь тухайн гэрчилгээнд заасан хугацаа дуусах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

**2 дугаар зүйл.**Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан дүрэм, журам, норм, нормативын баримт бичгүүдийг хууль хүчин төгөлдөр болсноос хойш 24 сарын хугацаанд үе шаттайгаар шинээр болон шинэчлэн боловсруулж батлах ба тэдгээрийг батлагдах хүртэлх хугацаанд тухайн харилцааг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журам, норм, нормативын баримт бичгээр зохицуулна.

**3 дугаар зүйл.**Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан ..... байгууллагыг сонгон шалгаруулахтай холбогдсон үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг .... оны .... дугаар сарын ....-ний өдрийн дотор багтаан боловсруулж батална.

**4 дүгээр зүйл.**Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан дүрэм, журмын дагуу ..... байгууллагыг байгуулах, түүний үйл ажиллагааг жигдрүүлэх ажлыг .... оны .... дугаар сарын ....-ний дотор хэрэгжүүлнэ.

**5 дугаар зүйл.**Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн ...-д заасан ..... мэргэжилтнийг, барилга байгууламжийг бүртгэлд хамруулах ажлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүргийн Засаг дарга хариуцаж, энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан хугацаанд зохион байгуулна.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны .... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасгай.

1/Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 47 дугаар зүйлд заасан Судалгаа хөгжүүлэлтийн байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталж, хэрэгжилтийг хангуулах;

2/Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлд заасан барилгын асуудал эрхэлсэн агентлаг, түүний бүтэц, орон тооны талаарх саналыг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

3/Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;

4/хүчин төгөлдөр мөрдөгдөж буй барилгын асуудалд хамаарах норм, дүрэм, журам, холбогдох бусад эрх зүйн актуудыг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн өөрчлөх, шинээр боловсруулах ажлыг зохион байгуулах;

5/Барилгын техникийн баримт бичиг боловсруулах ажлын төсөвт өртгөөс 0.18 хувиар авсан орлогыг Барилгын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан барилга байгууламжийн норм, нормативын сангийн эх үүсвэрт хамааруулах арга хэмжээг .... оны .... дугаар сарын ....-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх;

## ГАРЫН ҮСЭГ